



АГУУЛГА

- ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ
- ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ
- ТӨРИЙН БОДЛОГО
- УУЛ УУРХАЙ
- ХУДАЛДАА
- ҮЙЛЧИЛГЭЭ
- БОЛОВСРУУЛАХ
- БАРИЛГА
- ЦААШДЫН ТӨЛӨВ
- ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРСДЭЛ

М

онгол улс нь түүхий эдээ заран гадаад зах зээлээс мөнгө олдог, эргээд олсон мөнгөө импортын хэрэглээгээр гаргадаг уул уурхайд суурилсан бүтэцтэй, жижиг нээлттэй эдийн засагтай хөгжиж буй орнуудын нэг юм. Тиймээс ч урсгал тэнцлийн

алдагдал өндөр төдийгүй гадаад зах зээлээс хүчтэй хамаардаг. Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнийн уналт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт гэх мэт эрсдэлүүдээс хүчтэй хамаардаг. Та энэхүү тайлангаас голлох түүхий эдийн нөхцөл байдал, цаашдын хандлага, цар тахлын орчин дахь Монголын эдийн засаг, түүний эсрэг авч хэрэгжүүлсэн төсөв, мөнгөний бодлого, түүнчлэн салбаруудын нөхцөл байдал 2021 оны хандлагын талаар унших боломжтой.

ТҮҮХИЙ
ЭДИЙН
ЗАХ
ЗЭЭЛ




КОКСЖИХ НҮҮРС

Монгол улсын нийт нүүрсний экспортын 96 гаруй хувь нь Хятад улс руу экспортлогддог бөгөөд нүүрс нь нийт экспортын бараа бүтээгдэхүүний 40-өөд хувийг бүрдүүлдэг билээ. Тиймээс Хятадын зах зээлийн эрэлт болон засгийн газрын бодлогоос хараат байдаг. Хятад улсын импортын коксжих нүүрсний зах зээлийн 90-ээд хувийг зөвхөн Австрали болон манай улсын коксжих нүүрс бүрдүүлж байна.

- ☒ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл

Хятадын импортын нүүрсний зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Блүүмберг терминал


Оны эхээр COVID-19 цар тахлын улмаас дэлхий даяар хөл хорионы дэглэмд шилжсэн нь түүхий эдийн эрэлтийг доод хэмжээнд хүргэв. Монгол улс мөн адил тархалтаас сэргийлэх зорилгоор хилээ хааж экспортын үйл ажиллагаа завсардсан. Гэсэн ч энэ хугацаанд Хятадын дотоодын нийлүүлэлт зогссонтой холбоотойгоор импорт хэвийн хэмжээнд явагдаж Австралийн экспортод давуу тал олгов. Харин Монголын экспорт өнгөрсөн оны мөн үеэс 46 хувиар буурч, хил нээж экспорт сэргэхийн хэрээр дундаж үнэ ч буурсаар байна.

Өнгөрсөн онд Хятад болон Австрали улсын хооронд дипломат маргаан үүсч улмаар Хятад улс Австрали улсаас импортлох коксжих нүүрсний хэмжээнд квот тогтоосон. Энэ нь Монголын экспортын нүүрсний биет хэмжээг нэмэгдүүлж Хятадын импортын зах зээлийн гол түнш болгосны зэрэгцээ дундаж үнийг 95 ам.доллар хүртэл өсгөсөн.

Экспортын хэмжээ



Экспортын үнэ




Эх сурвалж: Блүүмберг терминал, Үндэсний Статистикийн Хороо

Ирээдүйн төлөв


Тогтвортой хөгжил болон агаарын бохирдлыг бууруулахыг чухалчилсан Хятадын "XIII дахь таван жилийн төлөвлөгөө"-ний дагуу 800 сая тоннын хүчин чадал бүхий нүүрсний уурхайнуудыг

хаасан. Үүнийг дагаад хүчин чадал өндөртэй, дэвшилтэт, хэмнэлттэй уурхайнуудыг улсынхаа хойд бүсэд нээсээр байна. Хятад улс жилд дунджаар 75 сая тонн коксжих нүүрс импортолдог. Олон улсад коронавирусын нөлөөгөөр гангийн эрэлт бага байгаа ч ирэх 2 жилд эрэлт харьцангуй тогтвортой буюу дунджаар 70 сая тонн байна гэж үзэж байна. Харин дэвшилтэт, шинэ уурхайнууд хуваарийн дагуу нээгдсээр байвал импортын коксжих нүүрсний эрэлт 2021 онд 5 сая тонн, 2022 онд 7 сая гаруй тонноор буурах төлөвтэй. хуваарийн дагуу нээгдсээр байвал импортын коксжих нүүрсний эрэлт 2021 онд 5 сая тонн, 2022 онд 7 сая гаруй тонноор буурах төлөвтэй.

Экспортын хэмжээний таамаг



Нүүрсний үнийн прогноз




Эх сурвалж: Блүүмберг терминал, Үндэсний Статистикийн Хороо

Нийлүүлэлт талаас харвал Монгол улс Транс – Монголын төмөр замаа өргөжүүлж, Таван Толгой – Ганцмод чиглэлийн төмөр замыг 2021 онд ашиглалтанд оруулахаар зорьж байгаа нь 2022 он гэхэд экспортын биет хэмжээг жилийн 40 сая тонн хүртэл өсгөх боломжтой. Ингэвэл Хятадын импортын нүүрсний талаас их хувийг бүрдүүлэх чадамжтай болох бөгөөд Австралийн нүүрсний өрсөлдөх чадварыг бууруулахаас гадна ханшийг бууруулна.

ГАЗРЫН ТОС

Коронавирусээс үүдэлтэй эрэлтийн сөрөг нөлөө түүхий эд дундаа газрын тосны зах зээлд хамгийн хүчтэй нөлөөлсөн. Газрын тосны зах зээлийн эрэлтийн 50 хувийг зам тээвэр, 15 гаруй хувийг агаарын тээвэр бүрдүүлдэг бол нийт нийлүүлэлтийн 30 гаруй хувийг ОПЕК хангадаг бөгөөд нийлүүлэлтээ танах журмаар газрын тосны үнийг хянаж байдаг. Тэгвэл улс орнууд хилээ хааж, хөл хорио тогтоосон нь газрын тосны эрэлтийг 40 хувиар бууруулсан бөгөөд энэ нь ханшийг 77 хувиар унагаж 2002 оноос хойших доод хэмжээнд хүргэсэн

Дэлхийн газрын тосны эрэлт ба нийлүүлэлт




Эх сурвалж: Блүүмберг терминал

Ингэснээр ОПЕК зах зээлд үүссэн эрэлтийн сөрөг нөлөөг тэнцвэржүүлэх зорилгоор түүхэн дээд хэмжээгээр гарцаа танах шийд гаргаж 5-р сараас 9.7 сая баррель, 8-р сараас оны эцэс хүртэл 7.7 сая баррелиар нийлүүлэлтээ танахаар болов. Өөрөөр хэлбэл дэлхийн нийт нийлүүлэлтийн 10 хувьтай тэнцэх хэмжээгээр бууруулсан. Энэ нь 5-р сараас эхлэн Brent тосны үнийг 2 дахин өсгөж, 6-р сараас одоог хүртэл 42-оос 45 ам.долларын хооронд тогтвортой хэлбэлзэж байгаа билээ.

Тэгвэл Орос улсаас нефтийн бүтээгдэхүүн импортлон хэрэглэдэг Монгол улсад энэхүү ханшийн хэлбэлзэл нь 3 сарын хоцрогдолтой нөлөөлж байна. Үүнээс харвал ирээдүйн 4 сард шатахууны үнэ өсөх төлөвтэй.

Бrent тосны үнэ ба АИ-92



Эх сурвалж: Блүүмберг терминал, Нийслэлийн Статистикийн Газар

Ирээдүйн төлөв

ОПЕК нийлүүлэлтээ он дуустал тогтмол сарын 7.7 сая баррелиар танаж, 2021 оноос сарын 5.8 сая баррелиар танах төлөвлөгөөтэй (ердийн үед дэлхийн газрын тосны нийлүүлэлт сарын 100 сая баррель байдаг). Тиймээс цаашид газрын тосны ханшыг эрэлт удирдана. Эрэлтийн дийлэнхийг буюу 20-оод хувийг АНУ дангаар бүрдүүлдэг ба АНУ дахь коронавирусийн тархалт, эдийн засгийн өсөлт, газрын тосны нөөцийн өөрчлөлт ханшид хамгийн их нөлөөлөхөөр байна.

Хөл хорио суларч зам болон агаарын тээвэр өсөж байгаа нь 5-р сараас эхлэн эрэлтийг аажмаар дэмжиж байгаа ч ердийн үеэс 10 хувиар бага байна. Энэ байдал 2022 он хүртэл үргэлжилж, эрэлт 2019 оны хэмжээнээс харьцангуй бага байх ч цаашид алгуур өсөх трендтэй байна. ДУА-гийн үзэж байгаагаар ханш 51 ам.доллар хүртэл өсөх боломжтой.

Ханшийн прогноз




Эх сурвалж: Блүүмберг терминал, Нийслэлийн Статистикийн Газар


ЗЭСИЙН БАЯЖМАЛ

Зэс нь үйлдвэрлэлд хамгийн өргөн хэрэглэгддэг таваар гэдэг утгаараа эдийн засгийн эрүүл мэндийн индикатор гэгддэг. Мөн сүүлийн саруудад зэсийн баяжмалын экспорт төвлөрүүлэх мөнгөн дүнгээр нүүрсний экспортын гүйцэтгэлийг давсан нь Монгол улсын эдийн засаг дахь нөлөөллийг харуулж байна. Экспортын эрдэс бүтээгдэхүүн дундаа зэсийг 100 хувь Хятад улс руу экспортолдог нь indicates the dependence and exposure of both export price and volume on a single market.

Экспортын хэмжээ




Зэсийн үнэ



Эх сурвалж: Блүүмберг терминал, Үндэсний Статистикийн Хороо

Өнгөрсөн онд дэлхийн нийт зэсийн хэрэглээний 51 хувийг Хятад бүрдүүлсэн ба жилд дунджаар 20 сая тонн зэсийн баяжмал болон зэсийн хүдэр импортолдог. Харин бодлогын хүрээнд 2017 оноос зэсийн хаягдал, боловсруулсан зэсийн импортыг багасгасаар байгаа. Тийм учраас Хятад улсын эдийн засгийн өсөлт ба олон улсын зэсийн үнэ эерэг корреляцитай байдаг. Тухайлбал энэ оны I улиралд эдийн засгийн өсөлт саарахад зэсийн үнэ 6,149 ам.доллараас 4,938 ам.доллар хүртэл буурах хариу үзүүлсэн.

Зэсийн импорт



Хятадын ДНБ өсөлт ба зэсийн үнэ



Эх сурвалж: Блүүмберг терминал


Зөвхөн зэсийн баяжмал экспортолдог манай улсын хувьд Хятадын зэсийн баяжмалын эрэлт өссөөр байгаа нь давуу тал болох ч сүүлийн жилүүдэд Хятад улсын импортын зэсийн зөвхөн 8 хувийг бүрдүүлж байна. Харин дийлэнхийг Чили улс нийлүүлдэг. Гэтэл Чили улсад коронавирусын голомт үүсч, халдвар өдөр ирэх тусам нэмэгдэж улмаар зэсийн уурхайгаа хаах хүртэл арга хэмжээг авсан. Энэ нь зах зээлд нийлүүлэлт хомстох айдсыг дагуулсны зэрэгцээ

Хятадын үйлдвэрлэл сэргэж эрэлт өсөв. Ингэснээр цар тахлын нөлөөгөөр ханш нь өссөн цөөн төрлийн таваарын нэг нь зэс болов.

Ирээдүйн төлөв

Хятад улсын эдийн засаг, болон үйлдвэрлэлийн гарц өсөж дэд бүтцийн хөгжилд их хэмжээний хөрөнгө оруулж байгаа нь зэсийн эрэлтийг ердийн үеэс ч өндөр төвшинд хүргэх боломжтой. Хятад улсын зэсийн хэрэглээ нэмэгдэж байгаа ч Европ болон Азийн бусад орнуудын эрэлт буурсантай холбогдуулан зах зээлд 100,000 тонн орчмын нийлүүлэлтийн илүүдэл зонхилно гэж үзэж байна (дэлхийн зэсийн эрэлт нийлүүлэлт харьцангуй тогтвортой байх бөгөөд дунджаар 30 сая тоннын хэрэглээтэй). Олон улс дахь зэсийн ханшийн хөдөлгөөн Монгол улсын хилийн үнэд нэг сараар хожуу нөлөөлдөг бөгөөд ирэх саруудад зэсийн үнэ буурахгүй, өсөх төлөвтэй.

Зэсийн баяжмалын үнийн прогноз




Эх сурвалж: Блүүмберг терминал

ТӨМРИЙН ХҮДЭР

Төмрийн хүдэр нь ган болон төмөрлөгийн гол түүхий эд бөгөөд зах зээл нь эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлөөс хамааралтай байна. Тэгвэл байгаль орчин хамгаалалтай холбоотойгоор Европ, АНУ-д гангийн үйлдвэрлэл буурч байгаа нь 2015 оноос дэлхийн төмрийн хүдрийн гарцыг бууруулсан. Цар тахал гарснаар дэлхийн гангийн эрэлт улам багасаж цаашид ердийн үеийн төвшин хүртэл сэргэх хандлагагүй байна.

Харин Хятад улсын гангийн эрэлт жил ирэх тусам нэмэгдсээр байгаа ба коронавирусийн нөлөөгөөр хязгаарлагдахгүй өссөн хэвээр байна. Энэ жил гэхэд эрэлт 1-ээс 2 хувиар өснө.

Гангийн үйлдвэрлэл



Эх сурвалж: Блүүмберг терминал


Төмрийн хүдрийн нөөц ба үнэ



Хятад улсын ever-growing эрэлтийг Бразил улс хангах боломжгүй болсны улмаас төмрийн хүдрийн үнэ эдийн засгийн хүнд үед унасангүй. COVID-19 вирусийн голомт Өмнөд Америкт хурдацтай тархаж байгаа нь улсуудыг эдийн засгийн үйл ажиллагаа болон түүхий эдийн тээвэрлэлтээ зогсооход хүргээд байгаа билээ. Ингэснээр Хятадын боомтууд дээр төмрийн хүдрийн нөөц эрс багасч тус түүхий эдийн үнэ өссөн.

Энэ нь Монголын төмрийн хүдрийн хилийн үнийг оны эхнээс 11 ам.доллараар өсгөхөд нөлөөлөв. Экспортын хэмжээний хувьд жилийн турш сард тогтмол 7.7-оос 8.5 сая тонныг экспортолсон хэвээр байна. Харин экспортын үнэд Хятад улсын эрэлт мөн Бразилын нийлүүлэлт хамгийн чухал байдаг.

Экспортын хэмжээ



Хилийн үнэ




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Цаашдын төлөв

Хятад улсын гангийн үйлдвэрлэл энэ онд 2 хувь өсөх таамагтай байгаа нь төмрийн хүдрийн эрэлтийг өсгөж байгаа ба энэ нь Монгол улсын экспортыг богино хугацаанд дэмжинэ. Харин Европ, АНУ-н гангийн үйлдвэрлэл 16 хувиар агших төлөвтэй байгаа нь Бразил, Австрали гэх томоохон нийлүүлэгч орнуудыг Хятад улс руу илүү хэмжээгээр экспортолход хүргэх нь. Ингэвэл нийлүүлэлтийн илүүдэл үүсч урт хугацаанд олон улсын болон манай экспортын түүхий эдийн үнийг унагаана.

Төмрийн хүдрийн үнийн прогноз




Эх сурвалж: Блүүмберг терминал

АЛТ

Алт нь төлбөр тооцооны хэрэгсэл, баялагийг хадгалах нэг хэлбэр, үйлдвэрлэлд ашиглагдах түүхий эд билээ. Корона вирус тархалтын энэ үед дэлхийн улс орнуудын эдийн засагт тодорхойгүй байдал, эрсдэл нэмэгдэж байгаа нь алтны үнэ цэнээ хадгалах шинжийг улам тодотгон өгч байна.

- ☒ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл

2020 оны 2-р сар хүртэл тогтвортой байсан АНУ-ын ажилгүйдлийн үзүүлэлтүүд вирусын тархалт эрчээ авч эхэлсний дараагаар огцом муудав. Тухайлбал ажилгүйдлийн түвшин 2020 оны эхний улирлын байдлаар 3.53% байсан бол 2020 оны 3-р улиралд 13.03% болж өсөв. Мөн долоо хоног бүрийн ажилгүйдлийн тэтгэмж анх удаагаа авч байгаа хүмүүсийн тоо дунджаар 243 байсан бол 3-р сарын 20-р дуусч буй долоо хоногт 3307 болж 13 дахин өссөн бөгөөд энэ үзүүлэлт тухайн сарын төгсгөлд 6867 хүртэл өссөн нь АНУ-ын холбооны нөөцийн санг бодлогын хүүгээ маш бага буюу 2011 оны хямралын дараах үетэй адил хэмжээнд буюу 0.25% хүртэл бууруулахад хүргэв. ХНС-ийн зүгээс эдийн засгийг сэргээх, уналтын үед нь дэмжих бүхий л арга хэмжээг авна гэдгээ зарлан эдийн засагт мөнгө хэвлэн нийлүүлэх, нээлттэй захаас үнэт цаас худалдан авах замаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэв. Үүний үр дүнд эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг хэмжих M2 Index 3-р сараас хойш 27%-иар өсч 18,402-д хүрэв.



Эх сурвалж: Bloomberg


Вирусын нөлөөгөөр хувьцаа, бонд, таваарын гэх мэтчилэн цохилт аваагүй зах зээл байгаагүй бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдыг эзэмшиж буй хөрөнгө оруулалтаа түргэн хугацаанд бэлэн мөнгөнд хөрвүүлэх өдөөлт болов. Үүний нөлөөгөөр алтны ханш 3-р сарын 10-аас 6 өдрийн дотор 1200\$-ын уналт хийж 1451\$-т хүрэв. Үүний дараагаар үнэ цэнээ хадгалах хөрөнгө оруулалтын эрэлт нэмэгдэж эхэлсэн бөгөөд алтны ханш аажмаар өссөөр 7-р сарын дунд үед 1800\$ хүрсэн байв. Хоёр гүрний харилцаа хурцдаж ханшийг огцом үсрэхэд хүргэв

7-р сарын 21-ий өдөр АНУ вирусын вакцины судалгааны дата баазад халдан мэдээлэл хулгайлсан хэргээр 2 Хятад хакерыг буруутгасан бөгөөд “Үндэсний мэдээллийн аюулгүй байдлыг хангах” шалтгаанаар АНУ-ын зүгээс Хятадын Хюстон дахь консулын газрыг албадан хаах шийдвэр гаргасан нь 2 гүрний харилцааг эргэн хурцатгах эхлэлийг тавив. Хятадын талаас хариу арга хэмжээ авч АНУ-ын Ченду дэх консулын газрыг албадан хаах шийдвэр гаргасан бөгөөд 8-р сарын 1-нд Трамп мөн “үндэсний мэдээллийн аюулгүй байдлыг хангах” шалтгаанаар Хятадын эзэмшилд байдаг богино хугацаат бичлэгийн TikTok аппликейшний АНУ дахь үйл ажиллагааг хязгаарлах шийдвэр гаргав. 2 улсын харилцаа хурцадсан нь тогтвортой өсч байсан алтны ханшийг 1800\$-с түүхэн дээд үнэ буюу 2075\$ хүртэл огцом өсөхөд хүргэлээ. Гэвч ханш үргэлж өсөөд байхгүй гэдгийг 8-р сарын 7-нд гарсан АНУ-ын ажилгүйдлийн сайжирсан мэдээ (Nonfarm payrolls) зарлагдсаны дараах 2%-ийн уналт, 8-р сарын 11-нд зарлагдсан ОХУ-ын вакцин батлагдсан мэдээллийн дараах 4%-ийн огцом уналтууд харуулж байна.

Ирээдүйн төлөв

Эдийн засгийн тодорхойгүй байдал, цаасан мөнгөний үнэгүйдэх эрсдлийн улмаас аажмаар өсч байсан алтны ханшийг 2 том гүрний харилцааны хурцадмал байдал огцом өсөхөд хүргэсэн бол энэ өсөлт нь үргэлж хадгалагдахгүй гэдгийг сүүлд тохиолдсон уналтууд болон ханшийн савалгаанууд харууллаа.

Томоохон байгууллагуудын алтны ханшийн таамаглал




Эх сурвалж: Bloomberg

Эдийн засгийн сэргэлт хэт удаан байх, вирусын шинэ тархалт гарч дахин хөл хорио тогтоох, зөөлөн мөнгөний бодлого барьсаар байх зэрэг нь алтны ханшийг дэмжих суурь шалтгаанууд болж өгөх бол эсрэгээрээ эдийн засаг хурдацтай сэргэж, вакцин батлагдан, хөл хориог сулруулах болон болиулснаар ханш унах нөхцөл бүрдэж өгнө. Одоогийн байдлаар нийт 180 орчим төрлийн вакцины хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд үүнээс 2 нь батлагдаад байгаа бол батлагдахаас өмнөх буюу 3-р шатандаа явж байгаа 8 төрлийн вакцин байна. Мөн улс орнууд вирусын тархалтыг хяналтандаа авч эхэлсэнээр хориог сулруулах болон байхгүй болгох шийдвэрүүд гаргаж байгаа нь эдийн засаг буцаад сэргэх нөхцлийг бүрдүүлж өгнө. Дээрх нь алтны ханш дунд болон урт хугацаандаа түүхэн дээд ханшаасаа унах магадлал өндөр байгааг харуулж байна. Эдийн засгаас хамаарсан хүчин зүйлээс гадна ханшид нөлөөлөх бас нэгэн чухал үйл явдал бол 11-р сард болох АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль билээ. Сонгуулийн үеэр улс төрийн тодорхойгүй байдал нэмэгдэх, мөн үүнтэй холбоотойгоор 2 улсын харилцаа илүү хурцадвал алтны ханш өсөхөөр байна. Эдийн засгийн тодорхойгүй байдлын улмаас дэлхийн томоохон санхүүгийн байгууллагуудын зүгээс алтны ирээдүйн төлөв байдлын талаар ялгаатай хүлээлттэй байгааг графикаас харж болж байна. Тухайлбал дараа оны сүүл улирал гэхэд ханш одоо байгаагаас өсч 2,300\$ хүрнэ гэсэн хүлээлттэй байгууллага байхад зарим банкны хувьд 1,683\$ хүртэл унана гэсэн хүлээлттэй байна. Харин дэлхийд томоохонд тооцогдох нийт 15 санхүүгийн байгууллагын дундаж хүлээлт дараа оны сүүлийн байдлаар 1,900\$ байна.

Алт ба Монголын зах зээл


Алтны экспорт нь Монгол улсын гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чухал үүрэгтэй. Алт олборлолт, түүний экспортыг нэмэгдүүлж Монгол улсын гадаад валютын нөөцийг зузаатгах зорилгоор анх 1991 онд "Алт", түүний дараагаар 2017 онд "Алт-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд олборлолт, тушаалттай холбоотой хууль эрхзүй, татварын орчныг боловсронгуй болгох, зохистой үйл ажиллагааг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын алтны экспорт



Оны эхэн үед корона вирусын тархалтыг хязгаарлах зорилгоор улсын хилийг хааж хөл хорио тогтоосон нь уурхайн үйл ажиллагаа эрхлэгч компаниудын үйл ажиллагааг зогсонги байдалд оруулахад хүргэв. Үүний улмаас 2020 оны эхний 4 сарын байдлаар Монгол улсын боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин бага байлаа. Гэвч 3-р сарын сүүлээр корона вирусын нөлөөгөөр алтны ханш олон улсын зах зээл дээр хурдацтайгаар өсч эхэлсэн бөгөөд нөгөө талаар Монголбанкны зүгээс алтны экспортыг эрчимжүүлэх зорилгоор холбогдох үйл ажиллагаа явуулдаг компани, уурхайнуудыг дэмжихээр нийт 500 тэрбум төгрөг хүртэлх 3-9 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэр олгож эхэлсний үр дүнд 7-р сарын эцсийн байдлаар нийт 18.9 тонн боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтыг экспортлов. Энэ нь өмнө оны нийт экспортоос 2 дахин илүү үзүүлэлт юм

Монгол улсын гадаад валютын нөөц болон түүнд эзлэх мөнгөжсөн алтны хэмжээ



Сүүлийн жилүүдэд Монгол улсын гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн бүрдүүлэлтэд алтны эзлэх хувь өссөөр байна. Тухайлбал 2019 онд дунджаар ГВАН-ийн 21.9 хувийг мөнгөжсөн алт бүрдүүлж байсан бол тус үзүүлэлт 2020 оны эхний хагасын байдлаар 30.4 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

- ☒ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл



ЦАР
ТАХЛЫН
НӨЛӨӨ


КОВИД-19 ба ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ

Жи­жиг нээлттэй эдийн засагт пандемик хүчтэй нөлөөлж байна

2020 он гарсаар цар тахал нь эдийн засагт хүчтэй нөлөөлөв. Улмаар 2020 оны 1-р улиралд эдийн засаг 10.7 хувиар, хагас жилийн байдлаар 9.7 хувиар агшсан байна. Хилийн хөл хорио уул уурхайн салбарт хүчтэй нөлөөлж, улмаар тус салбар 29.4 хувиар унасан. Харин уул уурхайн бус салбарын хувьд 4.4 хувиар агшсан байна.

- ☐ Түүхий эдийн зах зээл
- ☒ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл

Бодит ДНБ-н өсөлт




Дотооддоо цар тахал алдаагүй хэдий ч гадаад орчны нөлөөлөл эдийн засгийн идэвхжилд хүчтэй нөлөөлөв:

2016 оноос хойш тасралтгүй өсөж байсан түүхий эдийн үнэ худалдааны дайны нөлөөгөөр аажмаар буурч эхэлсэн. Түүнчлэн 2020 он гарсаар цар тахал дэлхий нийтэд тархаснаар дэлхийн эдийн засагт хүчтэй цохилт болсон. Улмаар улс орнуудын эдийн засаг агшиж эхэлсэн. Энэ нь түүхий эдээс хүчтэй хамааралтай манай улсад сөргөөр нөлөөлж байна. Гадаад орчны тодорхой бус байдлын голлох нөлөө нь манай улсын төлбөрийн тэнцэлд нөлөөлж, улмаар валютын ханшаар эдийн засагт нөлөөлдөг. 2019 онд төлбөрийн тэнцэл эерэг гарсан ч 2020 оны эхний хагас жилийн байдлаар төлбөрийн тэнцэл 1 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан билээ.

Гадаад худалдаа



Төлбөрийн тэнцэл





ТӨРИЙН
БОДЛОГО


ТӨСВИЙН БОЛОН МӨНГӨНИЙ БОДЛОГО

Эдийн засгийг дэмжих зорилгоор Монгол банкны зүгээс бодлогын хүүг 2 хувиар бууруулсан билээ.

Эдийн засгийн идэвхжил саарснаар инфляц буурч, 2020 оны 7-р сард 3.4 хувьтай байна. Инфляцийн бууралтад шатахууны үнэ буурсан нь голлон нөлөөлж байна. Инфляц төв банкны зорилтот түвшингээс бага байгаа учраас эдийн засгийг дэмжих зорилгоор Монголбанкны зүгээс бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж, 9 хувьд хүргэсэн. Гэсэн хэдий ч 2020 оны сүүлд тус бодлогын нөлөө гарах юм.

- ☐ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☒ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл

Инфляц, бодлогын хүү



Ам.долларын ханш



Долларын хадгаламж тасралтгүй өсч, эдийн засагт долларжилт эрчимтэй явагдаж байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурд он гарснаас хойш 1% хүртэл саарсан хэдий ч эргэн сэргэх хандлагатай байна. Мөнгөний нийлүүлэлт өсч байгаа нь голлон иргэдийн хадгаламж, тэр дундаа долларын хадгаламж огцом нэмэгдсэнтэй холбоотой байна. Экспортын орлого буурсантай холбоотойгоор иргэдийн ам долларын ханш чангарах хүлээлт нэмэгдэж улмаар 2020 оны 7-р сарын байдлаар долларын хадгаламж жилийн 57 хувиар өсөөд байна. Монгол банкны мөнгөний бодлогын хорооны мэдэгдлээр банкны системийн тогтвортой байдлыг хангах үүднээс банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг гаргасан. Энэхүү шийдвэр нь банкны системд нийт эх үүсвэрт долларжилт нэмэгдэхээс сэргийлж төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах юм.

Монгол банк дараах арга хэмжээнүүдийг авсан

- Төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 8.5 хувь болгож бууруулсан (324 тэрбум төгрөгийг зах зээлд гаргав)
- Нийт 76 мянга орчим зээлдэгчийн 663 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулж, сунгасан байна.
- Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засгийн хүндрэлтэй нөхцлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжүүлэх шийдвэр гаргав.

Засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тэрбум ₮	ДНБ-д эзлэх хувь
Татварын арга хэмжээ	1120	2.8
Ажилчдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх	771	2
Хувийн секторт ажиллаж буй ажилчдыг ХАОАТ-с чөлөөлөх	260	0.7
1.5 тэрбумаас доош орлоготой ААН-г ААНОАТ-с чөлөөлөх	30	0.1
Түрээсийн төлбөрөө 20 хувь бууруулсан ААН-г ХАОТ, ААНОТ-с чөлөөлөх	20	0.1
Эмнэлэг, хүнсний бүтээгдэхүүнийг НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх	12	0
Бусад	27	0.1
Зардлын арга хэмжээ	1045	2.6
Эрүүл мэндийн зардал	171	0.4
Хүүхдийн мөнгө	550	1.4
Малчдад бэлэн мөнгө шилжүүлэлт	200	0.5
Ноолуур үйлдвэрлэгчдэд татаас	27	0.1
Ажил олгогчдод олгох тэтгэмж	52	0.1
Бусад	45	0.1
Ипотекийн зээлийн хөтөлбөрийг эхлүүлэх	120	0.3
Тэтгэврийн зээл цуцлах	700	1.8
Алт олборлогчдод санхүүжилт олгох	500	1.3

Эдийн засгийн агшилтаас үүдсэн төсвийн тодотголоор 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай гарахаар байна: 2020 оны эхний 7 сард төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 18 хувиар буурчээ. Цар тахлын нөлөөгөөр төлөвлөсөн төсвийн орлого 1 их наяд төгрөгөөр тасарсан байна. Засгийн газрын зүгээс эдийн засгийг дэмжих 5.1 их наядын хөтөлбөрийг баталсан ч бодитоор 2.1 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Үр дүнд нь төсвийн зардал 34 хувиар өсөж, улмаар төсвийн алдагдал 2.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Хөтөлбөрийн зарим эх үүсвэрийг гаднаас зээл тусламж авах байдлаар зохицуулж байна. Тухайлбал, ОУВС болон АХБ-с нийтдээ 200 сая ам.долларын тусламж авсан бол цаашид донор орнуудаас 800 сая ам.доллар санхүүжилт авахаар яригдаж байна(Валютын албан нөөцийн 26 хувь). Төсвийн орлого тасарч, төсвийн зарлага нэмэгдэж байгаагаас оны төгсгөлд төсвийн алдагдал 4.8 их наяд орчим төгрөгийн алдагдалтай гарахаар байгааг сангийн яам төсөвлөөд байна.

Ирэх 4 жилд Засгийн газар 2.9 тэрбум ам.долларын гадаад бондын эргэн төлөлтийг хийх шаардлагатай. Гэвч эргэн төлөлтөд зориулсан нөөц хөрөнгө байхгүй учир Сангийн яамны зүгээс 1.2 их наяд төгрөгийг дахин санхүүжүүлэхээр зэхэж байна.


УУЛ
УУРХАЙ

20
20


УУЛ УУРХАЙН САЛБАР

Уул уурхайн салбар нь зэс, нүүрс, төмрийн хүдэр, алт зэрэг голлох түүхий эдийг үйлдвэрлэдэг салбар юм.

Уул уурхайн салбарын ДНБ-н өсөлт



Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт



2020 оны 7-р сарын байдлаар экспорт 28 хувиар буурсны гол нөлөөлөл нь нүүрсэн дээр байв. Нүүрсний тоо хэмжээ 2018, 2019 оны мөн үетэй харьцуулахад 2 дахин буурч, нийтдээ 12 сая тонн нүүрс гарсан байна. Харин зэсийн хувьд, тоо хэмжээ харьцангуй тогтвортой хэдий ч үнэ нь олон улсын зах зээлийг даган унасан. Сүүлийн саруудад Чилид цар тахал гарч, зэсийн нийлүүлэлт буурсантай холбоотой зэсийн үнэ өсөж байна. Улмаар уул уурхайн салбарын ДНБ-нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар 29 хувиар агшлаа.

2019 оны хувьд, Оюутолгойн зэсийн баяжмалын агууламж буурч, хөрөнгө оруулалт багассан жил болов. 2021 оны төсөөллөөр баяжмал дахь алтны агууламж нэмэгдэхээр байгаа нь 2020 оны нөхцөл байдлаас харьцангуй сайжирна гэж үзэж байна. Түүнчлэн цар тахлын давалгаа Чили-д хүчтэй нөлөөлж байгаа учраас энэ нь үнэ өндөр байх боломж олгож байна.

Нүүрсний салбарын хувьд, 2020 он нь хүнд жил байсан. Засгийн газраас 42 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж байсан ч оны төгсгөлд 27 сая тонн хүрэхээр байна. Гэсэн хэдий ч нүүрсний компаниудад алдагдал бараг нүүрлээгүй. Тиймээс үргэлжлүүлэн нүүрсээ экспортлох нь үйл ажиллагааг нь сэргээхэд нөлөөлнө. 2020 оны 8-р сарын байдлаар өдөр 2300 орчим машин гарч байгаа нь 2019 оны хэвийн түвшинд хүрч байна.

Уул уурхайн салбарын ДНБ нь 2020 онд 8 орчим хувиар агшихаар байна. Харин 2021 онд цар тахал дотоодод тархахгүй, цаашид Хятадын эдийн засаг сэргэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн уул уурхайн салбарын ДНБ-нь 11 хувиар өснө гэж харж байна. Нүүрсний үнэ өсөхгүй ч тоо хэмжээний хувьд өсөх боломжтой бол зэсийн үнэ цаашид өсөх хандлагатай байна. Түүнчлэн ОТ-н зэсийн баяжмалын агууламж нэмэгдэх нь экспортын орлого өсөхөд нөлөөлнө.

- ☐ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☒ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл




ХУДАЛДАА

ХУДАЛДААНЫ САЛБАР


Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж нь өөрөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчээс бараа, материал худалдан авч, ямар нэг нэмэлт боловсруулалт хийлгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар бол худалдааны салбар юм.

- ☐ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☒ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл

Худалдааны салбарын ДНБ-н өсөлт



Худалдааны салбарын борлуулалтын өсөлт



2020 оны эхний хагас жилийн байдлаар худалдааны салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн 13.3 хувиар буурчээ. Тус бууралтад голлон нөлөөлсөн хүчин зүйлс нь хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн(хүнд даацын тоног төхөөрөмж жилийн -16 хувь), шатахуун(жилийн -31 хувь), удаан эдэлгээтэй бараа(автомашин, цахилгаан бараа) –ны импортын худалдааны бууралт голлон нөлөөлсөн байна.

Цаашдын хандлага

Жижиглэнгийн салбарт өрхийн хэрэглээ голлон нөлөөлнө. Цар тахлын нөлөөгөөр өрхүүд хэрэглээний бүтэцдээ өөрчлөлт оруулж байна. Өөрөөр хэлбэл ирэх жилүүдэд орон сууц, машин, цахилгаан бараа хэрэгсэл худалдан авахаа түр азнаж, хурдан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүн авах нь өндөр байна.

Худалдааны салбарын өсөлтийг сааруулах хүчин зүйл уул уурхайн салбар. Уул уурхайн салбарын өсөлт саарч, түүнд чиглэсэн хөрөнгө оруулалт болох машин, техник тоног төхөөрөмж, эд анги болон нефтийн бүтээгдэхүүний импорт дээр өмнөх оноосоо төдийлөн өсөхөөргүй байна.

Хэдий тийм ч Сангийн яамнаас төсвийн тодотгол хийсний дараа 1 их наяд төгрөгө барилгын бүтээн байгуулалтад зарцуулагдана. Өөрөөр хэлбэл (1) ЗГ-н хөрөнгө оруулалтын зардалтай холбоотойгоор хөрөнгө оруулалтын импорт болох барилгын материал, техник, тоног төхөөрөмж, эд анги нэмэгдэх нь тус салбарын өсөлтөд эерэгээр нөлөөлнө гэсэн үг.




ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

Үйлчилгээний салбартаа тээвэр, санхүү даатгалын үйл ажиллагаа, үл хөдлөхийн үйл ажиллагааны салбар нь томоохон байр суурийг эзэлж байна.

Үйлчилгээний салбарын ДНБ-н өсөлт



Үйлчилгээний салбарын бүтэц



Уул уурхайн салбар саарсан нь тээврийн салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлөв. Мөн оны эхний хагаст ачаа тээвэр бараг зогссон. Ачаа тээврийн хувьд нүүрсний биет хэмжээ 2018, 2019 онуудад 36 сая тонн байв. Харин 2020 онд 27 орчим сая тонн байхаар байна(Коронавирус). 2021 онд уул уурхайн салбар сэргэж эхлэх тохиолдолд тээврийн салбар дагаж сэргэхээр байна. Нөгөөтэйгүүр 2020 онд гаалийн шинэчлэлийн ажил саатсан нь тус салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлөв. Тухайлбал, Гашуунсухайт боомт дээр зам, талбайн хэмжээ 4 дахин, экспортын хүчин чадал 2 дахин өсөхөөр байв.

Зочид буудал, аялал жуулчлалын салбар нь

хилийн хөл хорионоос шалтгаалан төдийлөн өсөхөөргүй байна. 2021 оны эхний хагас жил хүртэл агаарын хил нээгдэхгүй төлөвгүй. Түүнчлэн цар тахал гарсантай холбоотой 2021 онд аялал жуулчлал төдийлөн нэмэгдэхгүй гэж хүлээж байна. Жуулчдын тоо багасах нь зочид буудлын орлогыг дагаж бууруулдаг.

Санхүү, даатгалын үйл ажиллагааны салбар нь

бусад салбаруудыг бодвол цар тахлын нөлөөг тодорхой хугацааны дараа мэдэрч байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар тус салбарын актив 1 хувь, зээлийн хэмжээ 4 хувиар агшаад байна. Түүнчлэн эх үүсвэр талд ам.долларын хадгаламж 50 орчим хувиар өссөн бөгөөд долларжилт их явагдаж байна. Санхүүгийн секторын хувьд 2021 он нь нилээд сорилттой жил байхаар байна. Хэдийгээр Монголбанкнаас зээлийн чанарын ангилалд өөрчлөлт оруулж, хэрэглээний зээлийн төлөлтийг хойшлуулсан ч 2021 онд хэвийн нөхцөлд шилжих үед хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл өсөх хандлагатай болно.

Төрөөс хамааралтай салбаруудын хандлага.

Боловсрол, эрүүл мэнд, төрийн удирдлага гэх мэт төрөөс хамааралтай салбаруудын өсөлт 2021 онд саарахаар байна. 2021 оны хувьд төсөвт төрийн байгууллагын урсгал, хөрөнгө оруулалтын зардлаас илүүтэй хүүгийн төлбөр, бондын төлбөрийн асуудал их байгаа юм.



БОЛОВСРУУЛАХ


БОЛОВСРУУЛАХ САЛБАР

Боловсруулах үйлдвэрлэл нь түүхий эд, материалыг физик болон химийн аргаар хувиргаж шинэ бүтээгдэхүүн үүсгэх үйл ажиллагаа юм. Боловсруулах үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүн нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүнүүд орно.


Боловсруулах салбар нь Монголын хувьд маш олон төрлийн салбарыг дотроо шингээсэн байдаг учир тооцоход нилээд хүндрэл учруулдаг. Тус салбарын үйлдвэрлэлийн 50 хувийг хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл, 21 хувийг кокс, шахмал түлш үйлдвэрлэл эзэлж байна.

- ☐ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☒ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл

Боловсруулах салбарын ДНБ-н өсөлт



Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлт



Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл(боловсруулах салбарын 50 хувь):

Өрхийн орлого, өрхийн хэрэглээнд өсөлттэй байх нь хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн салбарыг дэмжихээр байна. Учир нь цар тахлаас хойш өрхийн хэрэглээний бүтцэд өөрчлөлт орсон бөгөөд түргэн эдэлгээтэй бараа бүтээгдэхүүнг ихээр хэрэглэх хүлээлттэй байна.

Кокс, шахмал түлш үйлдвэрлэл(салбарын 21 хувь):

Шахмал түлш нь агаарын бохирдол бууруулахтай холбоотойгоор түүхий нүүрсний оронд хэрэглэгдэхээр болсон. 2020 онд түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж эхлэхтэй холбоотой энэ төрлийн үйлдвэрлэл нэмэгдэхээр байгаа юм.


Боловсруулах салбарын өсөлтийн хандлага ямар байх вэ? Тус салбар нь 2016 оны сүүлээс эхэлсэн эдийн засгийн сэргэлтээс үүдэн 2017 онд 20 хувь, 2018 онд 16 хувь тус тус өндөр өсөлтийг үзүүлсэн. Тиймээс цар тахлаас шалтгаалан тус салбарын ДНБ-нь 2019, 2020 онуудад төдийлөн өндөр өсөхөөргүй байна. Бидний таамаглалаар 2020 онд 0.5 орчим хувиар өсөхөөр хүлээгдэж байна. Өсөлтийн голлох хэсэг нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс хамаарна.

БАРИЛГА


БАРИЛГЫН САЛБАР

Барилга угсралтын ажил эрчимтэй өрнөж байгаагийн дийлэнх хувь нь нийслэл Улаанбаатар хотод явагдаж байгаа бөгөөд үүнийг даган энгийн орон сууцаас гадна чинээлэг хэрэглэгчдэд зориулсан, тэдний хэрэгцээ шаардлагыг хангах тансаг зэрэглэлийн орон сууцууд олноор баригдаж байна. Мөн орон сууцны бус барилга, ялангуяа худалдаа, үйлчилгээний барилга угсралтын ажил эрчимтэй нэмэгдэж байгаа нь барилга угсралтын ажлын бүтцээс тодорхой харагдаж байна.

Барилгын салбарын ДНБ-н өсөлт



Барилгын салбарын бүтэц



Барилгын салбарын өсөлтийг юу дэмжих вэ?

8 хувийн зээл олголт саарсан, орон сууцны бодит эрэлт ханасан зэрэг нь орон сууцны барилгын борлуулалтад сөргөөр нөлөөлнө. Харин орон сууцны бус барилгын салбарт хэд хэдэн томоохон хүчин зүйл нөлөөлөхөөр байна. Төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар тус салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байгаа бол Тавантолгой-Зүүнбаянгийн төмөр замын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт нэмэгдвэл мөн л тус салбарыг хүчтэй дэмжихээр харагдаж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтад суусан барилга байгууламж.

2020 оны 1.3 их наяд орчим төгрөгтэй тэнцэхүйц хөрөнгө оруулалт тодотголын дараа батлагдав. Тус хөрөнгө оруулалт нь орон сууцны бус барилга, инженерийн байгууламж дээр нөлөөлөхөөр байна.

Барилгын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын урсгал.

Төсвийн хөрөнгө оруулалт болон төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтаар илүүтэй санхүүжигдэхээр байна. Харин барилгын салбарын чанаргүй зээл буурахгүй байгаа, барилгын борлуулалт буурч байгаатай холбоотойгоор банкуудын тус салбарт олгох зээл төдийлөн өснө гэж харагдахгүй байна.

Барилгын материал импорт.

Тус салбарт хийгдэх бүтээн байгуулалтын ажил нэмэгдэхтэй холбоотойгоор барилгын материалын импорт дагаж өсөхөөр байна. 2019 онд төдийлөн хүчтэй өсөөгүй(3 хувь), 2020 оны эхний хагас жилд цар тахалтай холбоотойгоор үргэлжлэн буурсан (-9 хувь). Тиймээс 2021 онд хийгдэх бүтээн байгуулалтын нөлөөгөөр өсөх боломжтой(төмөр зам, инженерийн барилга байгууламж).

- ☐ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☒ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☐ Хүлээгдэж буй эрсдэл

ЦААШДЫН ТӨЛӨВ

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Олон улсын байгууллагуудын зүгээс 6-р сард гаргасан тайланд Монголын эдийн засаг 2020 онд дунджаар 1-2 хувь агшихаар байгаа бол 2021 онд дунджаар 4-5 орчим хувьд өсөхөөр байна. Голомт банкны зүгээс 2020 онд эдийн засаг 2 хувиар агшиж, 2021 онд 5.1 хувиар өснө гэж хүлээж байна. Банкны үзүүлэлтийн хувьд, зээл болон хадгаламж өснө гэж хүлээхгүй байна. Хадгаламж 2020 оны төгсгөлд 0.4 орчим хувиар өсөхөөр байгаа бол зээл 0.7 хувиар агшихаар байна.

Хятад, АНУ-н асуудал, цар тахлын 2 дахь давалгаанаас үүдэн Хятадын эдийн засгийн сэргэлт удаашрах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч 2 дахь давалгааг Хятад улс хянах бололцоотой байна гэж үзэж байна. Энэхүү нөхцөл байдлаас үүдэн зэс, нүүрсний үнэ харгалзан 6000, 59 ам.долларт хүрнэ гэж олон улсын байгууллагууд таамаглаж байна. Түүхий эдийн үнэ аажмаар унаснаар уул уурхайн салбарт нөлөөлөх бөгөөд улмаар худалдаа, машин механизм, хүнд тоног төхөөрөмжийн борлуулалт сэргэх нь удаашрах төлөвтэй байна.

Үйлчилгээний бизнесүүдэд хэсэгчилсэн хөл хорио тавигдсан хэвээр байх нь үйлчилгээ, боловсруулах салбаруудад нөлөөлөх хандлагатай байна. Улмаар эдийн засаг аажмаар сэргэнэ гэж үзэж байгаа ч 2020 ондоо 2-4 хувиар агших төлөвтэй байна.

Үзүүлэлт	Гүйцэтгэл /YTD/				Таамаглал	
	2017	2018	2019	2020-Н1	2020*	2021*
Бодит ДНБ өсөлт	5.3%	7.2%	5.1%	-9.7%*	-2.0%	5.1%
ХАА	1.8%	4.5%	8.4%	13.0%	1.0%	3.5%
Уул уурхай	-5.5%	6.1%	-0.6%	-32.5%	-8.5%	11.3%
Боловсруулах	19.9%	15.7%	11.0%	-3.4%	0.2%	5.8%
Үйлчилгээ	5.4%	4.8%	5.6%	0.7%	-0.4%	6.2%
Худалдаа	6.8%	2.2%	7.2%	-12.4%	-4.3%	9.1%
Инфляци (оны төгсгөл)	6.4%	8.1%	5.2%	2.8%	3.0%	8.1%
M2 өсөлт	30.5%	22.8%	6.7%	5.0%	1.4%	5.6%
Ам. долларын ханш (оны төгсгөл)	2433.9	2637.4	2727.3	2823.8	2901.2	2966
Төлбөрийн тэнцэл, сая \$	1460.0	-141.7	44.0	-679.0	(1,758)	-330
Нүүрсний үнэ, \$	74	77	76	71	69	72
Зэсийн үнэ, \$	6,170	6,530	6,010	6,500	6,041	6481

- Түүхий эдийн зах зээл
- Цар тахлын нөлөө
- Төрийн бодлого
- Уул уурхай
- Худалдаа
- Үйлчилгээ
- Боловсруулах
- Барилга
- Цаашдын төлөв
- Хүлээгдэж буй эрсдэл



ХҮЛЭЭГДЭЖ
БУЙ ЭРСДЭЛ

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРСДЭЛ

Ирэх жилүүдэд Монголд учирч болох томоохон эрсдэлүүдийн биелэх магадлал болон эдийн засагт үзүүлэх нөлөөг зураглалаар харуулав. Одоогоор эдийн засагт хамгийн их нөлөөлж буй эрсдэл нь цар тахал болоод байна. Цар тахлын дэгдэлттэй холбоотой хилийн хорио, дэглэм зэрэг нь эдийн засгийн салбаруудад сөргөөр нөлөөлсөн хэвээр байна.


Эдийн засгийн эрсдэлийн дүр зураг

1-р түвшин. Эдийн засагт хамгийн нөлөөтэй бөгөөд биелэх магадлал өндөр хүлээгдэж буй эрсдэл нь цар тахал дахин дэгдэх, түүхий эдийн үнийн уналт, төсвийн алдагдал, улмаар гадаад өрийн эргэн төлөлт байхаар байна.

2-р түвшин. Эдийн засагт үзүүлэх нөлөө нь дээрх хоёр хүчин зүйлсээс харьцангуй бага боловч биелэх магадлал өндөртэй хүлээгдэж буй эрсдэл нь хар, саарал жагсаалт зэрэг байна. Гэвч энэ оны 10-р сард тус эрсдэлээс гарах боломж бий гэж харж байна.

3-р түвшин. Түүнээс гадна төлбөрийн тэнцлийн хямрал, зээлжих зэрэглэл, шууд хөрөнгө оруулалтын бууралт, өрхийн өрийн дарамт гэх мэтчилэн биелэх магадлал болон эдийн засагт үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй хүлээгдэж буй эрсдэлүүд байсаар байна.

Монголын эдийн засгийн топ эрсдэл



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Ирээдүйд бий болох эрсдэлийн зураглалаар биелэх магадлалтай болон эдийн засагт хүчтэй нөлөөлөхүйц эрсдэлүүд өндөр байна. Тус эрсдэлүүдийн дамжих механизмыг нь эдийн засгийн агент тус бүрээр харилцан адилгүй байна.

Сонгуулийн жил ба төсвийн алдагдал

Төсвийн алдагдал өндөр байх нь зээлжих зэрэглэл буурах, татвар нэмэгдэх, ханш сулрах, инфляц өсөх гэх мэт олон талын сөрөг үр дагавартай. 2020 оны 7-р сарын байдлаар төсвийн орлого 1 их наяд төгрөгөөр тасарч байна. Оны төгсгөлд энэхүү алдагдал 4.8 их наяд хүрэх төлөвтэй байна.

Цар тахал сонгуулийн жилтэй давхацсантай холбоотой эдийн засгийг дэмжих зорилгоор төсвийн зарцуулалт нь нийгмийн халамж, үйлчилгээнд илүү чиглэж байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын зардал өндөр байгаа нь хувийн сектор дахь хөрөнгө оруулалтаа шахах сөрөг нөлөөтэй. Өөрөөр хэлбэл хувийн аж ахуй нэгжүүдийг дэмжих нэртэй бага хүүтэй зээлүүд нь банк, санхүүгийн салбарын хөрөнгө оруулалтыг шахан гаргадаг гэсэн үг.

- ☐ Түүхий эдийн зах зээл
- ☐ Цар тахлын нөлөө
- ☐ Төрийн бодлого
- ☐ Уул уурхай
- ☐ Худалдаа
- ☐ Үйлчилгээ
- ☐ Боловсруулах
- ☐ Барилга
- ☐ Цаашдын төлөв
- ☒ Хүлээгдэж буй эрсдэл

Төсвийн алдагдал нь эдийн засагт сэргөөр нөлөөлөөд зогсохгүй ирээдүйд төлөгдөх гадаад бондын эргэн төлөлт хойшлох, мөнгөний бодлого явагдах орон зайг хязгаарлах зэрэг эрсдлийг давхар бий болгосоор байна.

Төлөвлөсөн төсвийн алдагдал, их наяд төгрөг




Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын бондын эргэн төлөлт.

2021-2024 онд томоохон бондуудын эргэн төлөгдөх хугацаа дуусч, дахин санхүүжилтийн эрсдэл нэмэгдэхээр байна. 2021 онд Мазаалай 500 сая ам.доллар, 2022 онд Чингис 1,000 сая ам.долларын үнэт цаасыг эргэн төлөх бол 2023-2024 онд Гэрэгз, Хуралдай төслүүдийн хүрээнд арилжаалсан 1,400 сая ам.долларыг хөрөнгө оруулагчдад эргэн төлнө. Мэдээж төсвийн 20, 30, 40 хувьтай тэнцэх мөнгийг улсын төсвөөс шууд гаргах боломжгүй. Тиймээс дахин санхүүжилт хийх зайлшгүй шаардлага тулгарна. Дахин санхүүжилт хийхийн эрсдэл нь хүүгийн хувь хэмжээ нэмэгдэх болон төгрөгийн ханш сулрахад өртөг нь өснө гэсэн үг. Дахин санхүүжилт хийх нь эдийн засагт нүүрлэж болох эрсдэлийг түр хугацаанд хойшлуулж байгаа л хэрэг юм.

Төлөвлөсөн төсвийн алдагдал, их наяд төгрөг



Handwriting practice lines consisting of 20 horizontal dotted lines.



ДУА СУДАЛГААНЫ ПЛАТФОРМ

Голомт банк нь Дуа вэб суурьтай судалгааны платформыг танд удахгүй хүргэж гэж байна. Тус платформаас та дараах мэдээллийг авах боломжтой.

- Макро эдийн засгийн судалгаа, тойм, цаашдын төлөв
- Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв
- Зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр гэх мэт голлох түүхийн эдийн зах зээлийн судалгаа
- Гибрид хадгаламж
- Байгууллагад зориулсан санхүүгийн зөвлөгөө
- Эдийн засгийн салбарын судалгаа
- Макро эдийн засгийн боловсруулсан тоон өгөгдөл
- Макро эдийн засгийн голлох үзүүлэлтийн таамаглал
- Зах зээлийн онцлох мэдээний анализ, эдийн засгийн нийтлэл

